



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА



Улаанбаатар хот  
2021



## МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ СУДАЛГАА

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн:

Ашигт малтмал, газрын тосны газрын

Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Цэгц

Уул уурхайн хэлтсийн мэргэжилтэн

Д.Бадамгарав

Ашигт малтмал, газрын тосны газар  
Монгол Улс, Улаанбаатар хот 15170,  
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3,  
Засгийн газрын XII байр, Баруун жигүүр  
Утас: 976-51-263934

Цахим шуудан: [info@mrpam.gov.mn](mailto:info@mrpam.gov.mn)

Цахим хаяг: [mrpam.gov.mn](http://mrpam.gov.mn)

### АГУУЛГА

1.	УДИРТГАЛ	3
1.1.	СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ	3

1.2. СУДАЛГААНЫ АРГА	6
1.2.1. СУДАЛГААНЫ АСУУЛТ	6
2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН	2
3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД	3
3.1. ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЭЛ ХЯЛБАР ОЛЖ АВАХ БОЛОМЖ	3
3.2. ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮНЭМШИЛТЭЙ БАЙДАЛ	5
3.3. УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	6
3.4. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ДҮРМИЙН ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ	7
3.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРМЫН ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ	9
3.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛСАН БАЙДАЛ	10
3.7. УУЛ УУРХАЙН ТАТВАРЫН ОРЧИН	11
3.8. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ	12
3.9. МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮРЭЛЦЭЭТЭЙ БАЙДАЛ	14
3.10. АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ	15
3.11. ГАЗРЫН ХАРИЛЦАА, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙДАЛ	16
3.12. ТӨР ЗАСГИЙН ЗҮГЭЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ	18
3.13. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА, ХАНДЛАГА	19
3.14. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖ	20
3.15. НУТГИЙН ИРГЭД БОЛОН УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА	22
3.16. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД ХЯЛБАР БАЙДАЛ	23
3.17. НИЙГМЭЭС УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАНДАЖ БАЙГАА ХАНДЛАГА	24
3.18. АВЛИГААС АНГИД БАЙДАЛ	26
3.19. ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ, МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР	27
3.20. ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, ХУВЬЦАА ЭЗЭМШИХ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖ	28
4. ДҮГНЭЛТ	29
5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ	32

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйл ажиллааны чиглэл .....	4
Зураг 2. Хөрөнгө оруулалт оруулсан хэлбэр .....	5
Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил .....	5
Зураг 4. Ашигт малтмалын төрөл .....	6


Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ.....	2
Зураг 6. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийн үнэлгээ.....	4
Зураг 7. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлын үнэлгээ.....	5
Зураг 8. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ .....	6
Зураг 9. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрмийн ойлгомжтой байдал .....	8
Зураг 10. Байгаль орчны хууль, дүрэм, журмын ойлгомжтой байдал.....	9
Зураг 11. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал .....	10
Зураг 12 Уул уурхайн татварын орчин .....	12
Зураг 13. Дэд бүтцийн хөгжил.....	13
Зураг 14. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал.....	14
Зураг 15. Амьдрах орчны аюулгүй байдал .....	15
Зураг 16.Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал.....	17
Зураг 17. Төр засгийн зүгээс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөөний үнэлгээ .....	18
Зураг 18. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа, хандлага .....	20
Зураг 18. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ..	21
Зураг 19.Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ .....	22
Зураг 20. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ .....	23
Зураг 21. Нийгмээс уул уурхайд хандах хандлагын үнэлгээ.....	25
Зураг 22. Авлигаас ангид байдлын үнэлгээ .....	26
Зураг 23. Ханган нийлүүлэгч, мэргэжлийн болон туслах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүртээмжтэй болон бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үнэлгээ.....	27
Зураг 24. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ .....	29

## 1. УДИРТГАЛ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах санал боловсруулах

### 1.1. СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ


Хөрөнгө оруулалтын орчны судалгаанд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг чиглэл тус бүрийн байгууллагуудыг хамруулахыг зорьсон бөгөөд нийт 122 байгууллага хамрагдсан.



Зураг 1. Үйл ажиллааны чиглэл

Судалгаанд оролцсон байгууллагуудаас ашигт малтмалын геологийн эрэл, хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 78.7% нь байсан бол боловсруулалт, худалдаа, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд үлдсэн хэсгийг нь бүрдүүлсэн.

Дээрх байгууллагуудын хөрөнгө оруулалт оруулсан байдлыг авч үзвэл 44% буюу ихэнх нь өөрийн хөрөнгийг төсөлдөө зарцуулсан бол 37% нь гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж, 12% нь банк санхүүгийн байгууллагаас зээл авч, хөрөнгийн зах зээл, төрийн хөрөнгө оруулалт, бонд, өрийн бичиг болон бусад байдлаар 7% нь хөрөнгө оруулжээ.




Зураг 2. Хөрөнгө оруулалт авсан хэлбэр

Үйл ажиллагаа явуулсан хугацааны хувьд байгуулагдаад удаагүй буюу 1-ээс 3 жил болж байгаа аж ахуйн нэгж 11.5%, 4-өөс 6 жил болж байгаа компаниуд 23%, 7-оос 10 жил болж байгаа аж ахуйн нэгж 17.2%-ийг эзэлж, 11-ээс 14 жил аж ахуй эрхэлж буй байгууллагууд 16.4%, 15-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагажсан байгууллагууд 32%-ийг тус тус бүрдүүлсэн байна.



Зураг 3. Үйл ажиллагаа явуулсан жил



*Зураг 4. Ашигт малтмалын төрөл*

Алтны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд хамгийн их хувь буюу 37.7%-ийг эзэлж, нүүрсний уурхай 17.2%, хайлуур жоншны уурхай 12.3%-ийг бүрдүүлсэн. Үлдсэн хэсгийг нь зэс, төмөр, гянтболд, цайр, хар тугалга болон бусад төрлийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд бүрдүүлсэн байна.

## 1.2. СУДАЛГААНЫ АРГА

Судалгааны ажлыг асуулга /анкет, асуумж/-ын аргаар авч, хөрөнгө оруулалтын орчны чиглэлийн асуултуудад үнэлгээ өгөх байдлаар хариултуудыг авч тухайн асуудлыг сайжруулах арга замын талаар санал авлаа.

### 1.2.1. Судалгааны асуулт

Судалгааны асуулга нийтдээ 27 асуулттай бөгөөд үүнээс 5 асуулт нь ерөнхий мэдээлэл авах асуулт, үлдсэн 22 нь үндсэн асуулт байсан. Үндсэн асуултуудаас 20 асуулт нь уул уурхайн хөрөнгө оруулалтын орчинд үнэлгээ өгөх хариулт болон сайжруулах саналыг авсан бол 1 асуулт нь өмнөх асуултуудад ороогүй чиглэл байвал санал өгч болохоор, 1 асуулт нь энэхүү судалгааны ажлыг цаашид сайжруулахад юу хийх талаар санал авахаар зохиогдсон. Асуултуудыг боловсруулахдаа олон улсад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг үнэлэхэд хэрэглэдэг үзүүлэлт болон манай орны нөхцөл байдалд тохируулсан асуултыг бэлтгэсэн болно.



Хөрөнгө оруулалтын орчинг үнэлж өгч, сайжруулах санал өгөх асуултууд:

1. Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж
2. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал
3. Улс төрийн тогтвортой байдал
4. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрмийн ойлгомжтой байдал
5. Байгаль орчны хууль, дүрэм, журмын ойлгомжтой байдал
6. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал
7. Уул уурхайн татварын орчин
8. Дэд бүтцийн хөгжил
9. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал
10. Амьдрах орчны аюулгүй байдал
11. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал
12. Төр засгийн зүгээс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө
13. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа, хандлага
14. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж
15. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа
16. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал
17. Нийгмээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага
18. Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал
19. Ханган нийлүүлэгч, мэргэжлийн болон туслах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүртээмжтэй болон бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар
20. Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж

Санал асуулгад оролцогч нь дээрх 20 үзүүлэлт тус бүрт өөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй одоогийн байдлыг бодолцон үзэж дараах 5 хариултын аль нэгийг сонгож үнэлэлт өгөхөөр зохицуулсан.

1. Маш муу
2. Муу
3. Дунд зэрэг
4. Сайн
5. Маш сайн

Асуулгын хариултыг интернетийн орчинд, биечлэн шууд асуултыг бөглөх зэрэг хэлбэрээр хүлээн авсан. Судалгаанд геологи, хайгуул, уул уурхайн олборлолт, баяжуулалт, боловсруулалт, хөрөнгө оруулалт, банк санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 1443 аж ахуйн нэгжийг хамруулахыг зорьсон боловч цахим хаяг ашиглагдахгүй болсон, холбоо барих утас нь буруу

Ашигт Малтмал,  
Газрын Тосны Газар

зэрэг шалтгаанаас болж асуулга хүргэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй бөгөөд  
122 байгууллага судалгаанд оролцож, асуулгад хариулт ирүүлжээ.


## 2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчинд 100 хүртэлх оноогоор үнэлэлт өгсөн. Судалгаанд оролцогчдоос ирүүлсэн хариултыг үнэлгээ тус бүрийн хувийн жинг гаргаж, жигнэсэн дундаж гаргах байдлаар тооцоолж нэгдсэн үнэлгээг тодорхойлсон.

Үнэлгээний 5 категори нь 100 онооны системд дараах онооны интервалтай байхаар тооцоолсон.

- маш муу үнэлгээ нь 34 хүртэл оноо,
- муу үнэлгээ нь 34-өөс 50 оноо,
- дунд үнэлгээ нь 50-аас 66 оноо,
- сайн үнэлгээ нь 66-аас 84 оноо,
- маш сайн үнэлгээ нь 84-өөс дээш оноо

Энэ жилийн хувьд нэгдсэн дүнгээр Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин **57.9** оноо авч **“Дунд зэрэг”** гэсэн дүнтэй гарсан байна. Судалгааны асуултуудаас маш сайн, сайн, маш муу үзүүлэлттэй асуулт гараагүй бөгөөд дунд ангилалд 14 үзүүлэлт, муу ангилалд 6 үзүүлэлт хамрагдав.



Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ

Хамгийн өндөр оноо авсан нь Ханган нийлүүлэгч, мэргэжлийн болон туслах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүртээмжтэй болон бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар /64.6 оноо/, Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж /62.0 оноо/, Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал /61.1 оноо/ байсан бол Амьдрах орчны аюулгүй байдал /58.5 оноо/, Төрийн байгууллага болон уул


уурхайн компаниуд хоорондын харилцаа, хандлага /57.4 оноо/, Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрмийн ойлгомжтой байдал /57.2 оноо/, Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж /57.2 оноо/, Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал /57.2 оноо/ гэсэн асуултууд нь дунд үзүүлэлт дотроо дээгүүр эрэмбэлэгдлээ. Харин Байгаль орчны хууль, дүрэм, журмын ойлгомжтой байдал /56.2 оноо/, Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал /55.9 оноо/, Уул уурхайн татварын орчин /53.9 оноо/, Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж /53.6 оноо/ Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал /53.3 оноо/, Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал /53.1 оноо/ үзүүлэлт нь дунд ангилалдаа доогуур жагсжээ.

Муу ангилалд орсон үзүүлэлтээс хамгийн тааруу дүн үзүүлсэн нь Улс төрийн тогтвортой байдал /38.4 оноо/ бол үүний дараа Нийгмээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлага /42.6 оноо/ орсон. Дараагийн түвшний тааруухан үзүүлэлт нь Төр засгийн зүгээс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө /45.2 оноо/, Дэд бүтцийн хөгжил /46.2 оноо/ байсан бол муу ангилал дотроо арай гайгүй үзүүлэлттэй байгаа нь Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал /46.7 оноо/, Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа /47.4 оноо/ байв.

### **3. ҮЗҮҮЛЭЛТҮҮД**


#### **3.1. ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЭЛ ХЯЛБАР ОЛЖ АВАХ БОЛОМЖ**

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологийн мэдээлэл хялбар авах боломж дунджаас дээгүүр буюу 62.0% байна. Нийт судалгаанд оролцогсодын 48.4% нь дунд зэрэг, 30.3% нь сайн, 15.6% нь муу, 4.1% нь маш муу, 1.6% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 6. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийн үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад цахимжуулж, онлайнаар үзэх, авах боломжтой болгох 42, нээлттэй, ил тод болгох 18, мэдээллийн сан, сайтын мэдээллийг шинэчлэх, сайжруулах 9, түгээлтийн сувгийг өргөжүүлэх 7 гэх мэт хариулт өгчээ.




Зураг 6.1. Геологийн мэдээлэл хялбар олж авах боломжийг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг Цахимжуулж, онлайнаар үзэх, авах боломжтой болгох, Нээлттэй, ил тод болгох гэсэн санал эзэлж байна.

### 3.2. ГЕОЛОГИ, ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮНЭМШИЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд геологи, хайгуулын ажлын үнэмшил 61.1% байна. Нийт судалгаанд оролцогсодын 56.6% нь дунд зэрэг, 23.8% нь сайн, 14.8% нь муу, 3.3% нь маш муу, 1.6% нь маш сайн гэж хариулсан байна.



*Зураг 7. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлын үнэлгээ*

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 27 аж ахуйн нэгж хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх, 20 аж ахуйн нэгж сургалт, гарын авлага, стандарт бий болгох, 8 аж ахуйн нэгж ажил хийх боломжийг хангах, хөрөнгө санхүүгээр дэмжих, 8 аж ахуйн нэгж мэргэжлийн хүнээр чанартай, нарийвчилж гүйцэтгэх, 5 аж ахуйн нэгж мэргэжлийн байгууллагыг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, 3 аж ахуйн нэгж ил тод, нээлттэй болгох гэсэн хариулт өгчээ.




Зураг 7.1. Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдлыг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 38.0%-ийг хяналтыг сайжруулах, баталгаажуулах, хариуцлагыг өндөржүүлэх гэсэн санал эзэлж байна.

### 3.3. УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ дунджаас доогуур буюу 38.4% байна. Нийт судалгаанд оролцогсодын 40.2% нь маш муу, 32.8% нь муу, 22.1% нь дунд зэрэг, 4.9% нь сайн гэж хариулсан байна.



Зураг 8. Улс төрийн тогтвортой байдлын үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 27 аж ахуйн нэгж бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах, 15 аж ахуйн нэгж удирдах болон гүйцэтгэх албан тушаалд мэргэжлийн хүнийг томилж, тогтвортой ажиллуулах, 14 аж ахуйн нэгж тогтолцоог өөрчлөх, 10 аж ахуйн нэгж салбарыг улс төр, намаас ангид байлгах, хамаарлыг багасгах, 8 аж ахуйн нэгж ЗГ, төрийн байгууллага тогтвортой байх, 7 аж ахуйн нэгж хууль хэрэгжүүлэх, 2 аж ахуйн нэгж улс төрчдийн хариуцлагыг сайжруулах гэх зэргээр хариулжээ.




*Зураг 8.1 Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулах санал*

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 32.5%-ийг бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах гэсэн санал эзэлж байна.

### **3.4. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ДҮРМИЙН ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ**

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлын үнэлгээ 57.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 46.7% нь дунд зэрэг, 21.3% нь муу, 20.5% нь сайн, 9% нь маш муу, 2.5% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 9. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрмийн ойлгомжтой байдал


Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 18 аж ахуйн нэгж батлагдсан хуулийг сурталчлан таниулах, сайн хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах, 17 аж ахуйн нэгж багасгах, хялбаршуулах, бодит байдалтай уялдуулах, 12 аж ахуйн нэгж мэргэжлийн судалгаа, хүмүүсийн саналыг авах, тус бүр 10 аж ахуйн нэгж хууль тогтоомжуудын уялдаа холбоог сайжруулах, орон нутгийн эрх мэдлийг багасгах, орон нутгийн захирамж хуулиас илүү гардаг, 7 аж ахуйн нэгж тодорхой, ойлгомжтой болгох, 2 аж ахуйн нэгж олон улсын жишиг судлах гэх зэргээр хариулжээ.



*Зураг 9.1 Уул уурхайн хууль, дүрмийн тодорхой байдлыг сайжруулах санал*

### **3.5. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРМЫН ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ**

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд байгаль орчны хууль, дүрэм, журмын ойлгомжтой байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 56.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 53.3% нь дунд зэрэг, 19.7% нь сайн, 15.6% нь муу, 11.5% нь маш муу гэж хариулсан байна.



*Зураг 10. Байгаль орчны хууль, дүрэм, журмын ойлгомжтой байдал*

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 14 аж ахуйн нэгж оновчтой, тодорхой болгох, 10 аж ахуйн нэгж орон нутгийн оролцоог багасгах, тус бүр 9 аж ахуйн нэгж ААН-үүдээс ирүүлсэн туршлага, саналд үндэслэн хууль дүрмээ сайжруулах, хуулиа хэрэгжүүлдэг, хариуцлагатай байх, 8 аж ахуйн нэгж хууль хоорондын болон дүрэм, журмыг уялдаатай болгох, 6 аж ахуйн нэгж нөхөн сэргээлтэд анхаарах, 5 аж ахуйн нэгж хууль тогтоомжийг сурталчлах, 3 аж ахуйн нэгж хялбаршуулах гэх зэргээр хариулжээ.




Зураг 10.1 Байгаль орчны хууль, дүрэм, журмыг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 21.9%-ийг оновчтой, тодорхой болгох гэсэн санал эзэлж байна.


### 3.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛСАН БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдлын үнэлгээ дунджаас доогуур буюу 46.7% байна. Нийт судалгаанд оролцогсодын 34.4% нь дунд зэрэг, 32.8% нь муу, 22.1% нь маш муу, 10.7% нь сайн гэж хариулсан байна.



Зураг 11. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 19 аж ахуйн нэгж хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах, ажиллах нөхцөлөөр хангах, 17 аж ахуйн нэгж хууль тодорхой, тогтвортой байх, 10 аж ахуйн нэгж хуульд өөрчлөлт оруулах, сайжруулах, 9 аж ахуйн нэгж хууль эрх зүйн орчныг сайжруулах, 3 аж ахуйн нэгж мэдээлэл сурталчилгаа хийх гэх мэтчилэн хариулжээ.




Зураг 11.1 Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийн хамгаалалтыг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 32.8%-ийг хөрөнгө оруулагчдыг дэмжих, хамгаалах, ажиллах нөхцөлөөр хангах гэсэн санал эзэлж байна.

### 3.7. УУЛ УУРХАЙН ТАТВАРЫН ОРЧИН

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд уул уурхайн татварын орчны үнэлгээ дунджаас дээгүүр буюу 53.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 45.1% нь дунд зэрэг, 25.4% нь муу, 18.0% нь сайн, 11.5% нь маш муу гэж хариулсан байна.



### Зураг 12 Уул уурхайн татварын орчин

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 19 аж ахуйн нэгж татварыг багасгах, хөнгөлөлт олгох, давхардуулж авахгүй байх, тус бүр 10 аж ахуйн нэгж уян хатан татварын системтэй болох, АМНАТ-ыг бууруулах, 8 аж ахуйн нэгж хуулийн заалтыг хянах, сайжруулах, ойлгомжтой болгох, 7 аж ахуйн нэгж хэрэгжилтийг сайжруулж, мэдээлэл сурталчилгаа хийх 5 аж ахуйн нэгж татварын орчныг тогтвортой байлгах, 4 аж ахуйн нэгж татварын нэгдсэн бодлогыг бий болгох гэх мэтээр хариулжээ.




Зураг 12.1 Уул уурхайн татварын орчныг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 30.2%-ийг татварыг багасгах, хөнгөлөлт олгох, давхардуулж авахгүй байх гэсэн санал эзэлж байна.

### 3.8. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд дэд бүтцийн хөгжлийн үнэлгээ дунджаас доогуур буюу 46.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 35.2% нь муу, 30.3% нь дунд зэрэг, 23.0% нь маш муу, 10.7% нь сайн, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 13. Дэд бүтцийн хөгжил

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 14 аж ахуйн нэгж төрийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөгөөр хөгжүүлэх, 11 аж ахуйн нэгж дэд бүтцийн орчныг сайжруулах, 9 аж ахуйн нэгж авто зам барих, засвар үйлчилгээг сайжруулах, 8 аж ахуйн нэгж төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, 7 аж ахуйн нэгж төмөр зам барих, тус бүр 5 аж ахуйн нэгж эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, 3 аж ахуйн нэгж боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, зохицуулалтыг сайжруулах гэх мэтээр хариулжээ.




Зураг 13.1 Дэд бүтцийг хөгжүүлэх санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 22.6%-ийг төрийн бодлого, урт хугацааны төлөвлөгөөгөөр хөгжүүлэх гэсэн санал эзэлж байна.

### 3.9. МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮРЭЛЦЭЭТЭЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 55.9% байна. Нийт судалгаанд оролцогсодын 45.9% нь дунд зэрэг, 31.1% нь муу, 18.9% нь сайн, 4.1% нь маш муу гэж хариулсан байна.



*Зураг 14. Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал*

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 21 аж ахуйн нэгж ажиллах нөхцөлийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, 20 аж ахуйн нэгж боловсон хүчнийг сайн бэлдэх, 12 аж ахуйн нэгж мэргэжлийн сургалт зохион байгуулах, тус бүр 9 аж ахуйн нэгж мэргэшүүлэх сургалтын төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, чанаржуулах, сайн сурталчлах, 3 аж ахуйн нэгж сургалтын системийг сайжруулах гэх мэтээр хариулжээ.




Зураг 14.1. Мэргэжлийн ажиллах хүчийг нэмэгдүүлэх санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 28.4%-ийг ажиллах нөхцөлийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх гэсэн санал эзэлж байна.

### 3.10. АМЬДРАХ ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд амьдрах орчны аюулгүй байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 58.5% байна. Нийт судалгаанд оролцогсодын 47.5% нь дунд зэрэг, 24.6% нь сайн, 13.9% нь муу, 11.5% нь маш муу, 2.5% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 15. Амьдрах орчны аюулгүй байдал

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 12 аж ахуйн нэгж стандартаа тодорхой болгох, мөрдүүлэх, хяналтыг сайжруулах, 11 аж ахуйн нэгж хэвийн ажиллах, аюулгүй амьдрах нөхцөлийг төрөөс дэмжих, орон нутгийн иргэдэд зөв ойлголт өгөх, 9 аж ахуйн нэгж дэд

бүтцийг сайжруулах, тус бүр 4 аж ахуйн нэгж агаар, хөрсний бохирдлыг үе шаттай бууруулах, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулах, хүнсний аюулгүй байдалд анхаарах, хүн бүр өөрсдийн болон бусдын аюулгүй байдалд анхаарч, хариуцлагатай байх талаар сурталчлан таниулах, тус бүр 3 аж ахуйн нэгж төслийн хөрөнгө оруулалтын шатанд зардлыг тусгах, тавигдах шаардлагыг сайжруулах, төвлөрлийг тараах нь амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулна гэх мэтээр хариулжээ.




*Зураг 15.1 Амьдрах орчны аюулгүй байдлыг сайжруулах санал*

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 24.0 %-ийг стандартаа тодорхой болгох, мөрдүүлэх, хяналтыг сайжруулах гэсэн санал эзэлж байна.

### **3.11. ГАЗРЫН ХАРИЛЦАА, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙДАЛ**

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд газрын харилцааны зохицуулалтын байдал дунджаас дээгүүр буюу 53.3% байна. Нийт судалгаанд оролцогсодын 40.2% нь дунд зэрэг, 23.8% нь муу, 19.7% нь сайн, 15.6% нь маш муу, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.



*Зураг 16. Газрын харилцаа, түүний зохицуулалтын байдал*

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 12 аж ахуйн нэгж газрын тухай хуулийг сайжруулах мөн ард иргэдэд сурталчилж таниулах, 7 аж ахуйн нэгж төлөвлөлт зохион байгуулалтыг сайн хийх, 6 аж ахуйн нэгж газрын харилцааны байгууллагуудыг нэгдсэн системтэй болгох, 5 аж ахуйн нэгж газрын төлбөрийн гэнэтийн өсөлт мөн давхар төлбөр төлөхийг зогсоох, тус бүр 4 аж ахуйн нэгж хүмүүст эрх тэгш мэдээлэл өгөх, шуурхай байх, авлигал, хүнд суртлыг арилгах, тус бүр 3 аж ахуйн нэгж мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах, байгууллага хоорондын уялдааг сайжруулах, 2 аж ахуйн нэгж давхардсан олон зөвшөөрөл авдаг байдлыг болих шаардлагатай гэх мэтээр хариулжээ.




### Зураг 13.1 Газрын харилцааны зохицуулалтыг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 26.1%-ийг газрын тухай хуулийг сайжруулах мөн ард иргэдэд сурталчилж таниулах гэсэн санал эзэлж байна.


### 3.12. ТӨР ЗАСГИЙН ЗҮГЭЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас үзэхэд хөрөнгө оруулалтын бодлогын үр нөлөөний үнэлгээ дунджаас доогуур буюу 45.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 33.6% нь дунд зэрэг, 32.0% нь муу, 25.4% нь маш муу, 9.0% нь сайн гэж хариулсан байна.



Зураг 17. Төр засгийн зүгээс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөөний үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 15 аж ахуйн нэгж хууль эрх зүйн орчныг сайжруулах, бодлогоо тодорхой болгох, 9 аж ахуйн нэгж ААН-ийг дэмжсэн бодлого баримтлах, тус бүр 5 аж ахуйн нэгж бодлого тогтвортой байх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, 4 аж ахуйн нэгж урт хугацаатай, хүү багатай дэмжих зээл гаргах, 1 аж ахуйн нэгж орон нутгийн эрх мэдлийг хязгаарлах гэх мэтээр хариулжээ.




*Зураг 17.1 Төр засгийн зүгээс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөөг сайжруулах санал*

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 38.5%-ийг хууль эрх зүйн орчныг сайжруулах, бодлогоо тодорхой болгох гэсэн санал эзэлж байна.

### **3.13. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА, ХАНДЛАГА**

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа, хандлага дунджаас дээгүүр буюу 57.4% байна. Нийт судалгаанд оролцогсодын 45.1% нь дунд зэрэг, 24.6% нь сайн, 16.4% нь муу, 12.3% нь маш муу, 1.6% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 18. Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа, хандлага

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 13 аж ахуйн нэгж харилцан дэмжлэг дээр суурилж ажиллах, 11 аж ахуйн нэгж зааварчилгаа, зөвлөмж өгөх, бичиг баримтын асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэх, 7 аж ахуйн нэгж хүнд суртлыг арилгах, тус бүр 6 аж ахуйн нэгж төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах, цахимаар үйлчилгээ үзүүлэх, 4 аж ахуйн нэгж хууль, дүрэм, журмаа мөрдөж ажиллах, тус бүр 2 аж ахуйн нэгж нэгдмэл ойлголттой, нэгдсэн системтэй болох, хууль журмаа сайжруулах, төрийн оролцоог багасгах гэх мэтээр хариулжээ.




Зураг 18.1 Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа, хандлагыг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 24.5%-ийг харилцан дэмжлэг дээр суурилж ажиллах гэсэн санал эзэлж байна.

### 3.14. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ дунджаас дээгүүр буюу 57.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 32.8% нь дунд зэрэг, 29.5% нь сайн, 22.1% нь муу, 13.1% нь маш муу, 2.5% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 19. Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийн үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 24 аж ахуйн нэгж бодлогоо зөв тодорхойлж, нэг ойлголт, хандлагаар хамтарч ажиллах, 7 аж ахуйн нэгж орон нутгийн удирдлагуудад мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгч байх, тус бүр 5 аж ахуйн нэгж хуулиас давсан дарамт шахалтыг зогсоох, зөвхөн хуулийн хүрээнд хамтран ажиллах, орон нутгийн оролцоог багасгах, 4 аж ахуйн нэгж мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тус бүр 3 аж ахуйн нэгж мэдээ, мэдээллийг сурталчилж таниулах, авлига, хүнд суртлыг арилгах, 2 аж ахуйн нэгж төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг байх хэрэгтэй гэх мэтээр хариулжээ.




*Зураг 18.1 Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломжийг сайжруулах санал*

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 45.3%-ийг бодлогоо зөв тодорхойлж, нэг ойлголт, хандлагаар хамтарч ажиллах гэсэн санал эзэлж байна.

### 3.15. НУТГИЙН ИРГЭД БОЛОН УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ дунджаас доогуур буюу 47.4% байна. Нийт судалгаанд оролцогсодын 31.1% нь дунд зэрэг, 28.7% нь маш муу, 23.8% нь муу, 14.8% нь сайн, 1.6% нь маш сайн гэж хариулсан байна.



*Зураг 20. Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааны үнэлгээ*

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 36 аж ахуйн нэгж уул уурхайн салбарыг таниулах, сурталчлах, ойлгуулах, 15 аж ахуйн нэгж харилцан ойлголцож, хамтран ажилладаг байх, 12 аж ахуйн нэгж асуудлыг тодорхой болгож хуульчилж өгөх, 5 аж ахуйн нэгж орон нутгийн эрх мэдлийг багасгах, тус бүр 2 аж ахуйн нэгж иргэд хуулиа дагаж мөрдөж ухамсарлах, хуулийн мэдлэг олгох, нэгдсэн бодлоготой болох гэх мэтээр хариулжээ.




Зураг 19.1 Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцааг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 50.0%-ийг уул уурхайн салбарыг таниулах, сурталчлах, ойлгуулах гэсэн санал эзэлж байна.


### 3.16. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД ХЯЛБАР БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 57.2% байна. Нийт судалгаанд оролцогсодын 41.8% нь дунд зэрэг, 23.0% нь муу, 22.1% нь сайн, 9.8% нь маш муу, 3.3% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 21. Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл авахад хялбар байдлын үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 19 аж ахуйн нэгж цахим болгох, 15 аж ахуйн нэгж олон шат дамжлагыг цөөрүүлэх, тус бүр 5 аж ахуйн нэгж хууль эрх зүйн орчинг сайжруулах, үйлчилгээг хуулийн хугацаанд хурдан шийдвэрлэх, 3 аж ахуйн нэгж өргөдлөөр талбайг өгдөг байх, тус бүр 2 аж ахуйн нэгж хүнд суртал, ашиг сонирхлын зөрчлийг арилгах, ил тод, шударга явуулах гэх зэргээр хариулсан байна.




Зураг 20.1 Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл авах ажиллагааг хялбаршуулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 37.3%-ийг цахим болгох гэсэн санал эзэлж байна.

### 3.17. НИЙГМЭЭС УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАНДАЖ БАЙГАА ХАНДЛАГА

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас нийгмээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагын үнэлгээ дунджаас доогуур буюу 42.6% байна. Нийт судалгаанд оролцогсодын 45.1% нь муу, 28.7% нь дунд зэрэг, 23.0% нь маш муу, 2.5% нь сайн, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 22. Нийгмээс уул уурхайд хандах хандлагын үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 45 аж ахуйн нэгж нийтэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх, 6 аж ахуйн нэгж хуулиар тодорхой нэгдсэн бодлоготой болох, 5 аж ахуйн нэгж хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, тус бүр 4 аж ахуйн нэгж нөхөн сэргээлтийн ажлыг сайжруулах, улстөржиж олон нийтийг турхирсан худал мэдээлэл тараах зэрэгт хяналт тавих, хариуцлага тооцох гэх мэтээр хариулжээ.




Зураг 21.1 Нийгмээс уул уурхайн үйл ажиллагаанд хандаж байгаа хандлагыг сайжруулах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 70.3%-ийг нийтэд бодит байдлыг ил тод, зөв мэдээллийг түгээх гэсэн санал эзэлж байна.

### 3.18. АВЛИГААС АНГИД БАЙДАЛ

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас авлигаас ангид байдлын үнэлгээ дундаж буюу 53.1% байна. Нийт судалгаанд оролцогсодын 41.8% нь дунд зэрэг, 29.5% нь муу, 16.4% нь сайн, 11.5% нь маш муу, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 23. Авлигаас ангид байдлын үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 12 аж ахуйн нэгж нээлттэй ил тод болгох, тус бүр 7 аж ахуйн нэгж цахим болгох, төрийн оролцоог багасгах, тус бүр 6 аж ахуйн нэгж авлига авсан албан хаагчид ногдуулах арга хэмжээг чангатгах, хуулийн хүрээнд ажиллах, 5 аж ахуйн нэгж хууль эрх зүйн орчинг сайжруулах, 3 аж ахуйн нэгж хүнд суртлыг арилгах, 2 аж ахуйн нэгж шат дамжлага, зөвшөөрлийн тоог багасгах гэх мэтээр хариулжээ.




Зураг 22.1 Авлигаас ангид байлгах санал

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 25.0 %-ийг нээлттэй ил тод болгох гэсэн санал эзэлж байна.


### 3.19. ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ, МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛОН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас туслан гүйцэтгэгчийн хүрэлцээ, чанарын үнэлгээ дунджаас дээгүүр буюу 64.6% байна. Нийт судалгаанд оролцогсодын 45.9% нь дунд зэрэг, 39.3% нь сайн, 9.8% нь муу, 4.1% нь маш муу, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 24. Ханган нийлүүлэгч, мэргэжлийн болон туслах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүртээмжтэй болон бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад тус бүр 8 аж ахуйн нэгж чанараа сайжруулах, хариуцлагатай, хугацаандаа нийлүүлдэг байх, хуулийн зохицуулалтыг сайжруулах, өндөр татвар, төлбөрийн дарамтыг багасгах, 6 аж ахуйн нэгж байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, сонгон шалгаруулалтыг шударгаар явуулах, тус бүр 4 аж ахуйн нэгж мэргэжлийн боловсон хүчний чадавхийг сайжруулах, сургалт зохион байгуулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, гэрээний нөхцөлийг илүү сайн чанартай болгох, тус бүр 1 аж ахуйн нэгж мэдээллээр хангах, уялдаа холбоог сайжруулах гэх мэтээр хариулжээ.




*Зураг 23.1 Ханган нийлүүлэгч, мэргэжлийн болон туслах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэмэгдүүлэх тэдгээрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах санал*

Сайжруулах саналаас хамгийн өндөр хувийг буюу 22.2 %-ийг чанараа сайжруулах, хариуцлагатай, хугацаандаа нийлүүлдэг байх, хуулийн зохицуулалтыг сайжруулах, өндөр татвар, төлбөрийн дарамтыг багасгах гэсэн санал эзэлж байна.

### **3.20. ХӨРӨНГӨ ОРУУЛАХ, ХУВЬЦАА ЭЗЭМШИХ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖ**

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн саналаас хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ дундаж буюу 53.6% байна. Нийт судалгаанд оролцогсодын 48.4% нь дунд зэрэг, 28.7% нь муу, 13.1% нь сайн, 9.0% нь маш муу, 0.8% нь маш сайн гэж хариулсан байна.



Зураг 25. Хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших мэдээлэл авах боломжийн үнэлгээ

Судалгаанд оролцогсодоос илгээсэн сайжруулах санал хүсэлтээс харахад 16 аж ахуйн нэгж Ил тод, нээлттэй болгох, тус бүр 7 аж ахуйн нэгж мэдээллийг илүү хүртээмжтэй болгох, мэдээллийг хялбар, ойлгомжтой байдлаар нийтэд түгээх, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, тус бүр 4 аж ахуйн нэгж мэдээллийг сайжруулах, мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжтой болгох, 3 аж ахуйн нэгж мэдээллийн нэгдсэн сан, платформ бий болгох гэх мэтээр хариулжээ.



Зураг 24.1 Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх санал

## 4. ДҮГНЭЛТ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны 2022 оны байдлыг судалж үзээд дараах дүгнэлтэд хүрлээ.

- Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ **57.9** оноо буюу **“ДУНД”** гэсэн үнэлгээтэй байна.
- Үнэлгээг нэгтгэн гаргасан 20 үзүүлэлтээс “маш сайн”, “сайн” гэсэн үнэлгээ гараагүй байгаа нь хөрөнгө оруулалтын орчин таатай гэж үзэх боломжгүй байна. Мөн “маш муу” гэсэн үзүүлэлт илрээгүй нөхцөл байдал хэт хүндрээгүй байгааг илтгэж байна.
- Хамгийн муу үзүүлэлт нь “Улс төрийн тогтвортой байдал” болсон шалтгаан нь сүүлийн жилүүдэд улс төрийн гэнэтийн шийдвэрүүд гарч, төрийн үйл ажиллагаа тогтвортой явахгүй, залгамж чанараа алдаж, төр засаг солигдох болгонд шинэ бодлого, хууль эрх зүйн орчин бий болж, урт хугацааны төлөвлөгөөтэй бодлого байхгүй, салбарыг мэргэжлийн бус хүн удирдаж, төрийн албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа болон улс төржилт нэмэгдсэнээс болсон.
- Дараагийн тааруухан үзүүлэлтэд “Нийгмээс уул уурхайн салбарт хандаж буй хандлага” орж байгаа нь ард иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл очихгүй, улс төрч, төрийн бус байгууллага худлаа, буруу мэдээлэл түгээж, популизм хийж байгаагийн зэрэгцээ хууль бус олборлолт, нөхөн сэргээлт хийдэггүй, хариуцлагатай уул уурхайг хангалттай хэмжээнд хөгжүүлэхгүй байгаатай холбоотой.
- Муу ангилал дотроо гайгүй үзүүлэлтэд “Нутгийн иргэд болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа”-д мэдлэг, мэдээлэл муу, “Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байдал”-д орон нутгийнхан болон ТББ-ууд саад учруулдаг, “Дэд бүтцийн хөгжил” сул байгаад төмөр зам, вагон дутагдалтай, зам харилцаа, дэд бүтэц муу, “Төр засгийн зүгээс хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах тал дээр авч хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө”-д бодлого хэрэгжүүлдэггүй, дэмжлэг байхгүй зэрэг голлох шалтгаанууд нөлөөлсөн байна.
- Дунд ангиллын доогуур жагсаж байгаа үзүүлэлтэд шат шатандаа хүнд сурталтай, авлигал нэхдэг байдлаар “Уул уурхайн салбарын авлигаас ангид байдал”, орон нутгийн оролцоо ихтэй, зохицуулалт муу, ил тод биш байдлаар “Газрын харилцааны зохицуулалт”, мэдээлэл хомс, хаалттай байдлаар “Уул уурхайд хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших талаарх мэдээлэл авах боломж”, давхардуулан олон төрлийн татвар авдаг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр өндөр зэргээс шалтгаалж “Уул уурхайн татварын орчин” гэсэн үзүүлэлтүүд багтлаа.
- Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай нь “Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээтэй байдал”-ыг, ойлгомжгүй, дагаж мөрдөхөд хүндрэлтэй, уялдаа холбоо муу шалтгаан нь “Байгаль орчны хууль, дүрэм, журмын ойлгомжтой байдал”-ыг, олон шат дамжлага нь “Үйл ажиллагаа

эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад хялбар байдал”, мөнгө, хандив, тусламж нэхдэг, уул уурхайн талаар ойлголтгүй, эсэргүүцдэг нь “Орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах боломж”-ийг, хуулийн давхардал, тодорхойгүй байдал, оновчгүй зохицуулалт нь “Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрмийн ойлгомжтой байдал”-ыг дунд ангилалд оруулсан байна.

- “Төрийн байгууллага болон уул уурхайн компаниуд хоорондын харилцаа, хандлага” нь хүнд суртал, дарамт шахалт их, “Амьдрах орчны аюулгүй байдал” нь агаарын бохирдол, ажиллаж амьдрах нөхцөл муу, “Геологи, хайгуулын ажлын үнэмшилтэй байдал” нь мэдээллүүд бодитой бус, зөрүүтэй, “Геологийн мэдээллийг хялбар олж авах боломж” нь мэдээлэл нээлттэй байдаггүй, цахимжаагүй, “Ханган нийлүүлэгч, мэргэжлийн болон туслах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хүртээмжтэй болон бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар” хугацаандаа ирдэггүй, хэт үнэтэй байгаагаас болж дунд ангилалд эрэмбэлэгджээ.

## 5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин 2022 оны байдлаар “Дунд” үнэлгээтэй болон үнэлгээний бүрэлдэхүүн үзүүлэлтүүд нь “маш сайн”, “сайн” үнэлгээнд хүрээгүй байгаа тул хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах шаардлагатай бөгөөд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.

- Улс төрийн тогтвортой байдлыг сайжруулахын тулд төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгаж, сайжруулж, урт хугацааны хөгжлийн бодлого гарган, түүнийгээ хэрэгжүүлэх механизмийг бий болгох шаардлагатай. Салбарын үйл ажиллагааг нам, улс төрийн үйл ажиллагаанаас хамаарал багатай байлгахыг хичээж, Засгийн газар, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой явуулахад анхаарч, төрийн албан хаагчдыг өөрчилдөггүй болгож, удирдах өндөр албан тушаалд мэргэжлийн хүнийг томилж, улс төрчид, иргэний хөдөлгөөний хариуцлагыг өндөржүүлж зохицуулах шаардлагатай.
- Олон нийтэд үнэн, бодит, салбарын талаар эерэг ойлголтыг өгөх мэдлэг, мэдээлэл өгөх сургалт, сурталчилгаа, PR-ийн ажлыг тогтмол зохион байгуулах, салбарын мэргэжилтнүүдэд зориулж ашигт малтмал, байгаль орчин, газрын харилцаа болон бусад холбогдох хууль эрх зүйн орчны талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл, сурталчилгааг нэгдсэн байдлаар ил тод, энгийн ойлгомжтой хэлбэрээр хүргүүлдэг онлайн платформыг бий болгож, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байгаа хариуцлагагүй, хууль бус олборлолт хийдэг, нөхөн сэргээлт хийх үүргээ биелүүлдэггүй иргэд, байгууллагын үйл ажиллагааг таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх ажлыг холбогдох хүчний байгууллагатай хамтран гүйцэтгэх.
- Аливаа гэнэтийн шийдвэр гаргахаас зайлсхийж, хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дэмжих тогтолцоог хэрэгжүүлэх, мэдээллээр хангаж ажиллах.
- Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай хүргэх үүднээс шаардлагатай мэдээллийг интернетийн орчинд байршуулж, тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрөл олгох ажиллагааны шат дарааллыг багасгаж, цахимаар өргөдөл хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх.
- Геологийн мэдээллийг цахимжуулж хөрөнгө оруулах сонирхолтой этгээдийг бодит мэдээллээр шуурхай хангаж, геологи хайгуулын ажлын хяналт, баталгаажуулалтын ажлыг сайжруулах тал дээр дэвшилтэт техник, технологийг ашиглаж, өндөр мэдлэг, туршлага бүхий хүмүүсийг оролцуулах боломжтой.
- Татварын орчны давхардал, бодит бус татвар ногдуулалт, тодорхойгүй байдлыг арилгахад анхаарч татвар, санхүүгийн холбогдох төрийн

Ашигт Малтмал,  
Газрын Тосны Газар

байгууллагуудтай хамтран ажиллаж, татварын орчныг таатай болгоход анхаарч ажиллах.